



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар

А/44

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйл, Иргэний хуулийн 339 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймаг дахь Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн 24 айлын орон сууцны халаалтын зуухны үйл ажиллгааг “Ашиглалтын гэрээ”-гээр “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ хариуцан явуулж байсныг Зэвсэгт хүчний 256 дугаар ангид шилжүүлэх болсонтой холбогдуулан халаалтын зуухны хөрөнгө, үйл ажиллагааг хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: -Г.Баясгалан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: -Б.Дэлгэрмаа аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Санхүү, өмчийн хадгалалт хамгаалалт хариуцсан мэргэжилтэн


-Б.Мөнхбат аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

-Д.Мягмар Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын дарга

-Д.Түмэнбаяр Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч

2. Хөрөнгийг акт үйлдэн хүлээлгэн өгч, “Хөрөнгө ашиглалтын гэрээ” байгуулан ажиллахыг ажлын хэсэг (Г.Баясгалан), Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн захирагч (Б.Галбадрах)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100214

D: My Doc. Tushaal. ZDTG